

БАТЛАВ.  
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН  
ДАРГА С.ҮНЭН

БАТЛАВ.  
ЦССҮТӨВ -ИЙН  
ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР

ЦЭВЭР УСААР ХАНГАХ, ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР  
УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

2016 оны 8 сарын 22 өдөр

Хэрэглэгчийн бүртгэл №340156

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Нэг талаас УСУГ түүнийг төлөөлж 2014 оны А/57 тоот тушаалыг үндэслэн гэрээний инженер албан тушаалтай П.БАТ-ОЮУН цаашид "хангагч" гэх, нөгөө талаас ЦССҮТӨВ-ийн захирал албан тушаалтай Н.ЭРДЭНЭБАЯР "хэрэглэгч" гэх нар нь Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 13 дугаар зүйл болон бусад холбогдох хуулийг удирдлага болгон 2016/08/22 -ны өдрөөс эхлэн дор дурьдсан нөхцлийг биелүүлж ажиллахаар харилцан тохиролцон ..... хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулж байна.
- 1.2. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Нийлүүлэх цэвэр ус болон татан зайлцуулах бохир усны хэмжээ, чанар, найрлага, төлбөр, тооцоо хийх

- 2.1. Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр ус болон хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан усны тоолуураар хэмжих ба хэрэглээг тоолуурын заалтыг үндэслэн тооцно. Тоолуурын заалтаар гарсан хэрэглэсэн цэвэр, бохир усны төлбөр болон бусад түүнтэй холбогдох төлбөрийг "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн батласан үнэ тарифийг мөрдлөгө болгон ажиллана.
- 2.2. Хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг тухайн хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээтэй тэнцүү гэж тооцно.
- 2.3. Үйлдвэр, аж ахуйн нэгжээс гарч байгаа бохир усны найрлага нь хотын бохир усны шугаманд нийлүүлэгдэх үед Дэд бүтцийн хөгжлийн сайд, Байгаль орчны сайд, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын хамтарсан а/11/05/A/18 тоот тушаалаар батлагдсан найрлагын зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн байвал бохирдуулагч нэмэгдэл тарифаар төлөх зарчмыг баримтлан төлбөр төлнө.
- 2.4. Усны тоолуурын заалтыг сар бурийн 01-14-ний хооронд хангагч, хэрэглэгчийн төлөөлөгч хамтран авч, хяналтын картанд харилцан гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 2.5. Төлбөрийн нэхэмжлэлийг төлбөр хийгдэхээр гэрээнд заасан хугацаанаас ажлын 5 хоногийн өмнө хэрэглэгчийн банкинд хүргэсэн байна.
- 2.6. Хангагч нь тухайн сарын усны төлбөрийг хэрэглэгчид мессежээр гэрээнд тэмдэглэсэн утасны дугаарт мэдээлэх ба мессежний төлбөрийг УСУГ-ын даргын 2011 оны №A/113 тоот тушаалын дагуу төлбөрт үйлчилгээний тарифаар төлбөрийн нэхэмжлэл дээр нэмж тооцно.
- 2.7. Хэрэглэгч нь төлбөрийн нэхэмжлэлийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.2-0.5 хувиар бодож алданги тооцно.

/Алданги тооцох хугацааг төлбөрийн нэхэмжлэл дээр тодорхой зааж өгнө./  
2.8.Хэрэглэгч нь төлбөрийн нэхэмжлэл тавьснаас хойш 10 хоногийн дотор буюу сар бүрийн 25-ны дотор бүрэн төлсөн байна.

2.9.Тоолуур, тооцооны хэмжих хэрэгсэл шаардлага хангагүй нь хэрэглэгчээс өөрөөс нь шалтгаалаагүй, эсвэл тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж засварлахаар шугамаас салгасан бол өмнөх 3 сард хэрэглэсэн цэвэр ус болон татан зайлуулсан бохир усны хэмжээний дунджаар тооцон зөвхөн 1 сар тооцоо хийнэ.

#### Гурав. Хангагчийн үүрэг

3.1.Хангагч нь хүн амын унд-ахуйн стандартад тохирсон цэвэр усаар хэрэглэгчийг тасралтгүй найдвартай хангаж, бохир усыг татан зайлуулна.

3.2.Хангагч нь төвийн цэвэр усны шугамын даралтыг 2 ата-аас багагүй байлгана.

3.3.Хангагч нь үйлдвэрлэл явуулж буй хэрэглэгчийн нийлүүлж байгаа технологийн бохир уснаас сар бүр дээж авна.

3.4.Усны тоолуурын найдвартай ажиллагааг хангах үүднээс хэрэглэгчдээс ирсэн хүсэлтийн дагуу тоолуур суурилуулах, баталгаажуулах, шалгах, засварлах зэрэг үйлчилгээг газрын даргын 2015 оны А/154 тоот тушаалын дагуу мөрдөж ажиллана.

3.5.Хэрэглэгчдийг УСУГ-ын үйл ажиллагаатай холбоотой хэрэгцээтэй мэдээллээр хангана.

3.6.Хэрэглэгчээс ирүүлсэн санал хүсэлт, гомдолыг хүлээн авч шуурхай барагдуулна.

3.7.Усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи болон бусад хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандaa мөрдлөг болгоно.

#### Дөрөв. Хэрэглэгчийн үүрэг

4.1.Гэрээ байгуулахаас өмнө хэрэглэгч усны тоолуурыг цэвэр усны шугамын оруулга дээр суурилуулсан байх ба тоолуурын зангилаа, түүний бүрэн бүтэн байдал, ашиглалт засвар үйлчилгээг хариуцна.

4.2.Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд зөвхөн хангагчийн зөвшөөрлөөр холбогдож, эрх бүхий ажилтаны хяналтан доор холболтыг гүйцэтгэнэ.

4.3.Хэрэглэгч нь хангагчийн эрх бүхий ажилтнуудыг цэвэр, бохир усны шугам сүлжээ, усны тоолуурын зангилаа зэргийг шалгах нөхцөл бололцоогоор хангана.

4.4.Хэрэглэгчийн усны тоолуур нь эвдэрсэн тохиолдолд хангагчид яаралтай мэдэгдэж, тоолуурыг баталгаажуулан суурилуулж 5 хоногийн дотор хэвийн ажиллагаанд оруулна.

4.5.Хэрэглэгчийн цэвэр, бохир усны шугам нь дундын эзэмшлийн шугамтай холбогдсон бол уг шугамын засвар үйлчилгээг тухайн хэрэглэгчидтэй хамтран гүйцэтгэнэ.

4.6.Хэрэглэгч нь Стандарт хэмжил зүйн газар болон хангагчийн тавьсан усны тоолуурын битүүмжлэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж, тоолуурын байрлал, холболтыг дур мэдэн өөрчлөхгүй байх

4.7.Хэрэглэгч нь технологийн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлэхдээ бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг баримтална.

4.8.Хэрэглэгч өөрийн байршил, харилцагч банк, дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох, өөрчлөгдөх бүр гэрээнд тодотгол хийлгэнэ.

арилгах шаардлагыг хүлээн авч биелүүлээгүй тохиолдолд

Долоо. Гэрээний үргэлжлэх хугацаа, гэрээ дүгнэх, нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах нөхцөл

7.1. Тус гэрээ байгуулсан өдрөөс эхлэн аль нэг талаас гэрээг цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгднө.

7.2. Хангагч, хэрэглэгч нь жилд нэг удаа гэрээг дүгнэж, дараа жилийн цэвэр, бохир усны гэрээнд тодотгол хийнэ. /Энэхүү заалт нь гэрээ байгуулсан хугацаа болон хэрэглэгчдийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарна /

7.3. Хэрэглэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн тохиолдолд цаашид гэрээг сунгах эсэх асуудлыг УСУГ-ын техникийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ

7.4. Хэрэглэгч нь аж ахуйн гэрээний 4.10 заалтыг хангаж ажлаагүй нөхцөлд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээ цуцлах арга хэмжээ авна.

7.5. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргасан тал нь 14 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. /Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. /

7.6 Хэрэглэгч нь цэвэр, бохир усны төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ 3 удаа биелүүлээгүй тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээг цуцлах арга хэмжээ авна.

7.7. Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс Орон сууцны ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хэрэглэгч нь тусгай зөвшөөрлөөр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авна.

7.8. Энэхүү гэрээтэй холбогдон хангагч ба хэрэглэгчийн хооронд гарсан аливаа маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Гэрээлэгчийн харилцах банк: Банкгүй

Дансны дугаар :

Хангагчийн талаас:

Утас: 77117703

Факс: 70157074


Хангагчийн талаас:

ХҮА-ны дарга

Гэрээний инженер



Хэрэглэгчийн талаас:



( гарын үсэг )

4.9 Хэрэглэгч байгууллага нь НӨАТ төлөгч бол Улсын бүртгэлийн гэрчилгээний нэр, НӨАТ төлөгчийн нэр, гэрээ байгуулагчийн нэр ижил байна.

4.10.Хэрэглэгч нь Хот суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.10 заалт, УСУГ-ын даргын №А/24 тоот тушаалын дагуу хангагчаас олгосон техникийн нөхцөл, зөвшөөрөл, батлагдсан зураг төслийн дагуу өөрийн эзэмшлийн шугамаас бусад хэрэглэгчийг холбуулах үүрэгтэй

4.11.Усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи болон бусад хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

4.12.Хэрэглэгч нь энэхүү гэрээний нэмэлт заалтанд тусгагдсан үүргийг гэрээний нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

4.13.Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цэвэр усны шугамын алдагдал, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хангагчаас тогтоосон хугацаанд засварлна.

4.14.Хот, суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан үүргийг хүлээнэ.

#### Тав. Хүлээх хариуцлага

5.1.Өөрийн ашигладаг тоног төхөөрөмжинд засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс хангач болон бусад хэрэглэгчийн ус хангамжийн үйл ажиллагаа saatсан бол гарсан хохирлыг хэрэглэгч бүрэн барагдуулна.

5.2.Хангагч нь өөрийн буруугаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэрэглэгчийн ус хангамжийг тасалдуулсан бол тэр хугацаанд ногдох усны төлбөрөөс чөлөөлнө.

5.3.Хэрэглэгч нь зөвшөөрөлгүйгээр буюу зөвшөөрөлгүй цэгт бохир ус нийлүүлсэн тохиолдолд Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

5.4 Хэрэглэгч нь энэхүү гэрээний заалтуудыг зөрчсөн тохиолдолд Хот, суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан хариуцлагыг нэгэн адил хүлээнэ.

Зургаа. Цэвэр усаар хангах ба бохир ус татан зайлцуулалтыг хязгаарлах, зогсоох нөхцлийн

6.1.Хангагч нь хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр орон нутгийн засаг захиргааны зөвшөөрөлгүйгээр цэвэр усаар хангах, бохир усиг татан зайлцуулах ажиллагааг Хот суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах тохиолдолд хэсэгчлэн болон бүрэн зогсоно.Үүнд:

6.1.1.Хангагчтай байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн буюу гэрээний хугацаа дууссан зөрчил илэрсэн үед

6.1.2.Усны төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй

6.1.3.Хангагч байгууллагын зөвшөөрөлгүйгээр дамжин хэрэглэгчийг цэвэр усаар хангаж, бохир усиг татан зайлцуулсан тохиодолд

6.1.4.Хангагчаас зохих зөвшөөрөл авсан дамжин хэрэглэгчийг цэвэр бохир усны шугам сүлжээнд холбооос үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдолд

6.1.5.Хангагчийн эрх бүхий ажилтныг усны тоолуурын зангилаа, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид үзлэг шалгалт хийх, усны тоолуурын заалт авах, бохир усны дээж авч хэмжилт хийх, лац ломбо суурилуулах, цэвэр усны горимын тооцоо хийх гэх мэт ажлыг хийж гүйцэтгэхэд санаатайгаар саад учруулсан тохиолдолд

6.1.6.Тухайн хэрэглэгчийн эзэмшил дээрх ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн бүрэн бус байдлын талаар илэрсэн зөрчлийг

ЦЭВЭР УСААР ХАНГАХ, ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ  
340156 ТООТ АЖ АХҮЙН ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ

Хэрэглэгч та "Борлуулалтын үйл ажиллагаа"-ны 2 дугаар циклийн хэрэглэгч байна.

**1. Тоолуурын заалт авах, бичилт хийх, нэхэмжлэл бэлтгэх үйл ажиллагаа:**

- 1.1 2 дугаар цикльд хамрагдаж байгаа хэрэглэгчийн усны тоолуурын заалтыг сар бүрийн 09-аас 15-ны хооронд авах бөгөөд хангагч, хэрэглэгчийн төлөөлөгч хамтран хяналтын картанд харилцан гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
- 1.2 Төлбөрийн нэхэмжлэлийг сар бүрийн 15-ны дотор хэрэглэгчийн үндсэн гэрээнд бүртгэлтэй банкинд хүргэсэн байна. Хэрэв хэрэглэгчийн банк, данс өөрчлөгдсөн тохиолдолд нэмэлт гэрээний 1.2-т заасан хугацаанаас ажлын 3 хоногийн өмнө хангагч байгууллагад мэдэгдэнэ.
- 1.3 Хангагч нь усны төлбөрийн мэдээллийг сар бүрийн 15-ны өдөр хэрэглэгчийн үндсэн гэрээнд бүртгэлтэй утасны дугаарт мессежээр илгээнэ. Хэрэв мессеж хүлээж авах утасны дугаар өөрчлөгдсөн нөхцөлд нэмэлт гэрээний 1.2-т заасан хугацаанаас ажлын 3 хоногийн өмнө хангагч байгууллагад мэдэгдэнэ.
- 1.4 Мөн хангагч нь усны төлбөрийн нэхэмжлэх болон тооцооны хуудсыг сар бүрийн 15-ны өдөр хэрэглэгчийн үндсэн гэрээнд бүртгэлтэй e-mail хаягаар илгээнэ. Хэрэв e-mail хаяг өөрчлөгдсөн нөхцөлд нэмэлт гэрээний 1.2-т заасан хугацаанаас ажлын 3 хоногийн өмнө хангагч байгууллагад мэдэгдэнэ.
- 1.5 Мөн хангагч нь сар бүрийн 17-18-ны өдрүүдэд хэрэглэгчийн төлбөр төлөх эцсийн хугацааг мессежээр сануулна.
- 1.6 2 дугаар циклийн хэрэглэгч та төлбөрийн нэхэмжлэл банкинд хүргэгдсэнээс хойш 7 хоногийн дотор буюу сар бүрийн 21-ний дотор усны төлбөрөө бүрэн төлсөн байна.

**2. Авлага барагдуулах үйл ажиллагаа**

- 2.1 2 дугаар циклийн хэрэглэгч та 1.6-д заасан хугацаанд усны төлбөрөө төлөөгүй тохиолдолд алданги тооцож эхэлсэн тухай мессежийг илгээх бөгөөд алдангийг хоног тутамд нийт төлбөрийн 0.2 хувиар тооцно.
- 2.2 Мөн урьдчилан мэдэгдсэнд үндсэн дээр 22-ны өдрөөс ус хангамжийг хязгаарлах арга хэмжээг авна.
- 2.3 2 дугаар циклийн хэрэглэгч та усны төлбөрийн улмаас усаа хязгаарлуулсан тохиолдолд усны төлбөрөө бүрэн төлөх мөн ус хаалгаж, нээлгэсний төлбөрийг төлбөрт үйлчилгээний журмын дагуу төлж өр авлагын тооцоогүй болсон тохиолдолд хангагч байгууллага ус хангамжийг нээж протокол хөтөлнө.
- 2.4 Жилд 3-аас дээш удаа дээрхи төрлийн протокол хөтлөгдсөн хэрэглэгч та найдваргүй хэцүү хэрэглэгчийн бүртгэлд бүртгэгдэж гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 2.5 Борлуулалтын үйл ажиллагааны шинэ дэг жаягаар ажиллаж эхэлсэнтэй холбогдон үндсэн гэрээний 2.4, 2.5, 2.8 заалтыг хүчингүй болсонд тооцно.

**3. Хяналт шалгалтын талаар:**

- 3.1 Хэрэглэгч нь хангагчийн эрх бүхий ажилтнуудыг шугам сүлжээ, тоног төхөөрөмж, тоолуурын зангилаанд үзлэг, шалгалт хийж, заавар зөвлөгөө өгөх нөхцөл бололцоогоор хангана.

ХАНГАГЧ ТАЛААС:

ХҮА-НЫ ДАРГА:

ГЭРЭЭНИЙ ИНЖЕНЕР:




ХЭРЭГЛЭГЧИЙН ТАЛААС:

*Ч.Батбек*



**Зааг эзэмшлийн зураг**  
Байгууллагын нэр: ЦССҮТӨВ

PRODUCED BY AN AUTODESK EDUCATIONAL PRODUCT



Ус Сувгийн Удирдах Газар			он	Тэмдэглэгээ	
Хянасан		П.БАТ-ОЮУН	сар	барилга	
Тогтоосон	Л.Дугармаа 99008949	Л.Дугармаа	өдөр		
Зөвшөөрсөн	Н.ЭРДЭНЭБАЯР				



## ГЭРЭЭ ХИЙХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Хэрэглэгчийн нэр: ЦССҮТӨВ

Факс:

Емайл:

Албан тушаал:

Захирал Н.ЭРДЭНЭБАЯР  
СТСБ-ын албаны дарга С.Батболд  
Менежер  
Инженер  
Бусад

Утас: 312857  
99072449

Улсын бүртгэлийн дугаар: 9070001138

Хэрэглэгчийн регистрийн дугаар: 9128905

Хэрэглэгчийн НӨАТ төлөгчийн гэрчилгээний дугаар:

Шуудангийн хаяг:

Хэрэглэгчийн хаяг: БЗД 3-р хороо

Байршил: 2-р эмнэлэгийн хашаанд

Хэрэглэгчийн харьцаг банк: Банкгүй

Дансны дугаар:

### Үйл ажилгааны чиглэл:

Төсөв:	Эмнэлэг
Аж ахуй:	
Орон сууц:	
Үйлдвэр:	
Бохирдуулагч үйлдвэр	

### Холболт:

Цэвэр ус:	
Төвлөрсөн системээс	X
Гэр хорооллын шугам	
Гүний худагтай	
Зөөврөөр	
Бусад	
Бохир ус:	
Төвийн коллекторт	X
Цооногтой	
Бохиргүй	
Бусад	

### Бусад мэдээлэл:

Барилгын талбай м2	0
Давхрын тоо:	4
Байрны тоо	0
Ажиллах цаг	0
Ажлын хоног	0
Хүний тоо	0
Төнөглөлтийн тоо:	
Угаалтуур	0
Суултуур	0
Писсаур	0
Банн	0
Шүршүүр	0

### Тоолуурын тухай

Тоолуурын дугаар	Тоолуурын голч/мм/	Тоолуурын оронгийн тоо	Гэрчилгээний дугаар	Тоолуурын төрөл	Марк	Баталгаажсан огноо	Суурилуулсан огноо	Тоолуурын анхны заалт
15030086	15	5	030132273	Хүйтэн	LXSC	2015/07/23	2016/08/22	0

Хэрэглэгчийн гэрээний дугаар: 340156

Төлбөрийн дунг мессежээр хүлээн авах утасны дугаар: 99072449

Хэрэглэсэн усанд төлбөр тавих хугацаа:  Сар

Улирал

Гэрээний төрөл:  Байнгын

Түр

Гэрээ өөрчлөх болсон шалтгаан: Шинэ хэрэглэгч

Энэхүү хэсгийг УСУГ-ийн ажилтан бөглөнө.

Техникийн нөхцлийн дугаар: 548/11

Худгийн тоо: 2

Цэвэр усны цагирагийн дугаар: 59

Худгийн тоо: 3

Бохир усны коллекторын дугаар:

Оруулга шугамын голч /мм-ээр/:

П.БАТ-ОЮУН  
хангачийн гарын үсэг



Н.ЭРДЭНЭБАЯР  
хэрэглэгчийн гарын үсэг